



Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгээс дараах зовломжийг нийт ард иргэддээ хүргэж, сэрэмжлүүлж байна. Араатан амьтан, чоно, нохойд хазуулснаас үүсэх халдварт овчноос хамгийн аюултай нь галзуу овчин юм. Амьтны шүлсэнд байгаа вирус нь гэмтсэн арьсаар дамжиж халдвар үүсгэдэг. Амьтанд хазуулсан шархыг бага гэж үл тоомсорлож болохгүй. Амьтанд хазуулсан хүнд анхны тусламж үзүүлэхдээ цус гоожилтыг зогсоох гэж яарсны хэрэггүй.

Урьдчилан сэргийлэлт:

- Галзуу овчтэй болон сэжигтэй зэрлэг болон гэрийн тэжээмэл амьтанд хазуулахгүй байх
- Гэрийн тэжээмэл нохой муурыг галзуугийн урьдчилан сэргийлэх тарилгад хамруулах
- Хорхой шавьж, мэрэгч тэжээвэр болон зэрлэг амьтанд хазуулсан шархыг амаараа бvв сор

Авах арга хэмжээ:

- Хазуулсан, ноцуулсан, шүлсдүүлсэн тохиолдол гарвал тэр даруйдаа шархыг цэвэрлэн ариутгах,
- Галзуугийн эсрэг ийлдэс, урьдчилан сэргийлэх вакциныг зааврын дагуу цаг алдалгвй тариулах
- Эмнэлгийн тусламж авах хүртэл шархыг буцалсан бүлээн усаар сайтар савандаж угаан спирт болон иодоор арчих
- Гэрийн тэжээмэл нохой муурыг галзуугийн урьдчилан сэргийлэх тарилгад хамруулах
- Том хэмжээний шарх үүссэн, цус алдаж байгаа үед угааж цэвэрлэх аргыг хэрэглэхгвй. Яаралтай эмнэлэгт очих

Шавьж хорхойд хатгуулах:

Зуны улиралд хүмүүс зогий, хэдгэнэ, могойд хатгуулах нь элбэг тохиолддог. Шавьжинд хатгуулсан дороо овдож улайн хавддаг. Зогийд цоон хатгуулсан бол хордлого үүсгэхгвй. Харин зогийн дайралтад ортож маш олон тооны гүвдрүү, хавдар үүссэн бол амь насанд аюултай. Харшилтай хүн зогий, шумуултай газар явахдаа харшлын эсрэг эмээ биедээ байнга авч явах хэрэгтэй. Зогийд хатгуулсан тохиолдолд хатгуур нь арьсанд үлддэг.

Авах арга хэмжээ:

- Арьсанд үлдсэн зогийний хошууг болгоомжтой шахаж гаргах
- Шархыг нь иод, спиртээр арчих

- Овчин намдаах, тайвшруулах эм огох

- Арьс бамбайж хавдах, хоолой соонгодох, хамар битvvрэх зэрэг харшлын шинж илэрвэл эмнэлэгт яаралтай хандах

Могойд хатгуулах

Могойд хатгуулсан бол юуны омно тэр могойн хортой эсэхийг мэдэх нь чухал. Могойд хатгуулсан хэсгийг ходолгож болохгvй. Ходолгох тусам хор нь биеэр тvргэн тархдаг байна. Хэрэв холийг хатгасан бол тэр хvн огт гишгэж болохгvй.

Шинж тэмдэг:

- Хатгуулсан газарт улайж хавдана.

- Хохорч цус хурна.

- Хордлогын шинж илэрч таталт огно.

- Шингэн ууж чадахгvй болно.

- Нас барах шалтгаан гол толов амьсгалын дутагдлаас болно.

- Хортой могойд хатгуулсан бол амь насанд аюултай.

Авах арга хэмжээ:

- Хатгуулсан газрыг амаараа сорж болохгвй.
- Эмчийн зовшооролгвйгээр овчин намдаах эм, аспирин ууж болохгвй.
- Хатгуулсан дороо 1-2 минутад хатгуулсан газрын дээд талд чангалуур тавина.
- Овдолт их бол овчин намдаах эм огч болно.
- Шингэн звйл их уулгах
- Эмнэлэгт яаралтай хандах
- Мос нь овдолт намдаах,хорыг тархаахгвй байхад тустай
- Хорны тархалтыг удаашруулахын тулд хатгуулсан хэсгийг оргон зоолон юм уу цэвэр даавуугаар ороож боох
- Хол гарыг ходолгоонгвй барьж чангахан боох /судасны лугшилт мэдэгдэхээр /
- Могойд хатгуулсан хэсгийг ходолгож болохгвй. /Ходолгох тусам хор нь биеэр твргэн тархдаг /

- Хэрэв холийг хатгасан бол тэр хvн огт гишгэж болохгvй

Нийгмийн эрvvл мэндийн хvрээлэн